



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 21/487


Хэрлэн сум

Өвөлжилтийн бэлтгэл хангахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 20,179,860 (хорин сая, нэг зуун далан есөн мянга, найман зуун жаран) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.
- 2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
- 3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.
- 4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 09 дугаар сарын 25-ны
А/137 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Байгууллага, сумдын нэр	Мөнгөн дүн
1	Байгаль орчин аялал жуулчлалын газар	6,587,700
2	Бор-Өндөр сум	13,592,160
Нийт дүн		20,179,860